

Байгууллагын нэр: "УЛААНБААТАР ЛИФТ" НӨҮГ

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ  
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин (Тоо, хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (МЯН.ТӨГ)	Тайлбар
Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	6-аас дээш	Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдсан сургалтад холбогдох ажилчид хамрагдаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. - НЗДТГ-аас төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Шударга ёсыг эрхэмлэе" нийслэлийн зөвлөгөөнийг 2022 оны 04-р сарын 04-ний өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа нар оролцлоо. - Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны 04-р сарын 06-ны өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа сургалтад хамрагдлаа. - Шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын талаарх албан хаагчдад зориулсан сургалтад 2022		

				<p>оны 05 дугаар сарын 10-ны өдөр ажилтан З.Ариунтуяа, Б.Уянга, Я.Батбаатар, Б.Лхагвабаяр нар хамрагдсан. Тус сургалтаар архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичиг хэрхэн боловсруулах, стандартын дагуу зохиож бүрдүүлэх талаар мэдлэг чадвараа дээшлүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад 2022 оны 05 дугаар сарын 10, 12-ны өдөр 8 ажилтан хамрагдаж мэдлэг чадвараа нэмэгдүүлээ.</p> <p>- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичгийг боловсруулах арга зүй" сэдэвт сургалтад 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 8 ажилтан хамрагдаж мэдлэг чадвараа нэмэгдүүлээ.</p> <p>- "Нийслэл-110" Менторшип хөтөлбөрийн нэгдүгээр шатны хөтөлбөрт Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа амжилттай оролцсон бөгөөд хоёрдугаар шатандаа тэнцсэн. Тус хөтөлбөрийн гол зорилго нь мэдлэг туршлагатай, хүлээн зөвшөөрөгдсөн төрийн албан хаагч өөрийн мэдлэг, туршлагаа шинээр томилогдсон албан хаагчтай хуваалцах, тэднийг чиг үүргээ үр нөлөөтэй, бүтээмжтэй хэрэгжүүлэхэд зөв чиглүүлэх, туслах замаар мэдлэг, мэргэшил, ур чадварыг нь нэмэгдүүлэх юм.</p> <p>- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Stress management" сэдэвт сургалтад Ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа, Нярав-Тоо</p>
--	--	--	--	--



	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	Ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд www.ubliff.ub.gov.mn цахим хуудсаар болон бусад хэлбэрээр нийтэд ил тод мэдээлэн тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан хүнийг сонгон шалгаруулж ажилд авч байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс Ахлах нягтлан бодогч-1, Жолооч-1, Хяналтын инженер-2 буюу нийт 2 ажилтанг тус тус сонгон шалгаруулж ажилд авсан. Манай байгууллага 3 болон түүнээс дээш жил ажилласан 13 ажилтантай. (Хэрэгжилт: 86 хувь)		Манай байгууллага 18 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.
	<b>Хэсгийн дундаж:</b>				<b>93 хувь</b>		
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин, биелэлтийг тоочон холбогдох шагнал, урамшууллыг 6 ажилтанд олгуулсан. Үүнд: Ерөнхий инженер М.Энхбат Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар, Лифтийн механик Б.Дашдондог, Л.Сүхчулуун нар БХБЯ-ны "Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан"-аар, Механик инженер Я.Батбаатар, Үйлчлэгч Ц.Энхбаяр нар БХБЯ-ны "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдсан. (Хэрэгжилт: 100 хувь)		
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадвар, зэрэг дэвийн нэмэгдлийг сар бүр нийт ажилтнуудад олгож байна. (Хэрэгжилт: 100%)	Гүйцэтгэлээр	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадвар, зэрэг дэвийн нэмэгдлийг сар бүр нийт ажилтнуудад олгож байна. (Хэрэгжилт: 100%)	14,681.8	

		ОЛГОХ нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах				Нийслэлийн Засаг даргын 2012 оны 03 дугаар сарын 15-ны "Улаанбаатар лифт" НӨҮГ-ын дүрэм, бүтэц, орон тоог батлах, даргыг томилох тухай А/184 дүгээр захирамжийн хавсралтаар байгууллагын дүрмийг баталсан байдаг ба дүрмийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Газар нь Баянзүрх дүүргийн Намьянжугийн гудамж XIII дугаар хорооллын XV хорооны 6-р байрны зүүн талд байрлах хуучин өрхийн эмнэлгийн барилгад байрлана" гэж заасан байдаг. Манай байгууллага одоог хүртэл уг барилгад үйл ажиллагаагаа явуулж байна.
4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Манай байгууллага цэвэр, бохир, дулаан, цахилгааны шугаманд бүрэн холбогдсон, 7 өрөө бүхий 108 м <sup>2</sup> талбайтай 1 давхар тоосгон байшинд үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын байр нь технологийн болон эрүүл ахуйн стандартад нийцсэн гэрэлтүүлэг, агааржуулалт, дулааны хангалтаар хангагдсан, ажлын ширээ, сандал, компьютер техник хэрэгслээр тоноглогдсон ба ажилчдыг хөдөлмөрийн ая таатай нөхцөлөөр бүрэн хангасан. Ажилчдын сэтгэл ханамж 100 хувь. (Хэрэгжилт: 100 хувь)	1,843.1	
	Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Албан хаагчдын сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	Албан хаагчдын хоол унааны зардалд өдрийн 5000 төгрөгийг олгож байсан бөгөөд нэмэгдэж 7000 төгрөг болсон. (Хэрэгжилт: 100 хувь)	21,780.0	
5	Албан хаагчдын эрүүл мэндийг	Эрүүл мэндийн урьдчилан	Жилд 1-ээс доошгүй удаа	- "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хуулийн 14.1 дэх хэсэг, "Улаанбаатар Лифт" НӨҮГ-ын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл	-	Байгууллагын төсөвт ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх

		<p>хамгаалах, урьдчилан сэргийлэх</p>	<p>сэргийлэх үзлэг</p>	<p>ахуйн” журмын 2.3.1 дэх заалтад заасны дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг орон даяар хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан байгууллагын нийт албан хаагчдыг энэ үзлэгт хуваарийн дагуу бүрэн хамруулна. Тайлант хугацаанд 12 ажилтан хуваарийн дагуу хамрагдсан бөгөөд 5 ажилтан хамрагдах дарааллаа хүлээж байна. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор</p> <p>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар Марафонд нэгдэцгээе” нийслэлийн засаг даргын нэрэмжит шилжин явах цомыг 2022 оны 05-р сарын 02-ны өдөр “Геодези, усны барилга, байгууламжийн газар” ОНӨААТҮГ-аас хүлээн авч, 2022 оны 05-р сарын 03-ны өдөр “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” ОНӨТҮГ-т хүлээлгэн өглөө. Аяны хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Ажлын байрны дасгал хөдөлгөөн</li> <li>2.100м-ийн гүйлтийн тэмцээн (эрэгтэй, эмэгтэй)</li> <li>3.Нийт албан хаагчдын дунд 1500м-ийн марафон</li> </ol>		<p>үйл ажиллагаанд зардал тусгагдаагүй.</p>
--	--	---------------------------------------	------------------------	---	--	---

	<p>4. Албан хаагчдын дунд сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн</p> <p>5. Шатар, даамны тэмцээнийг тус тус зохион байгууллаа.</p> <p>- Байгууллагын нийт ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, тогтмол дасгал хөдөлгөөнтэй байлгах зорилгоор Улаанбаатар хотын ШУЗТөвтэй хамтран сард 2 удаа ШШГЕГ-ын харьяа "Сүлд" БТСХороотой гэрээ байгуулан хамтран ажилласан.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/546 дугаар захирамжийн хүрээнд "Улаанбаатар марафон" олон улсын гүйлтэд 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ирц бүрэн оролцлоо.</p> <p>(Хэрэгжилт: 100 хувь)</p>		
	<p>Албан хаагчид 100 хувь хамрагдсан. (Хэрэгжилт: 100 хувь)</p>	<p>100 хувь</p>	
	<p>Хэсгийн дундаж:</p>	<p>100 хувь</p>	
	<p>Үнэлгээний дундаж хувь:</p>	<p>100 хувь</p>	
		<p>98 хувь</p>	



ТАНИЛЦСАН:  
ДАРГА

Д.ГАН-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

*(Signature)*

Ц.ӨСӨХЖАРГАЛ